

МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН “АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2023 оны 07 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр уг хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, энэ хөтөлбөрийн хүрээнд аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг хөгжүүлэх авто зам барих, төвлөрсөн дулаан хангамж, ус зайлуулах хоолой, бохир усны хоолойг барихад зарцуулах хөрөнгө оруулалт нь хэр оновчтой болох, 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургах, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, бүсчилсэн хөгжлийн үндэсний зургаан бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасныг өөрчилж, эрчимжсэн хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх зэрэг шаардлагатай төсөл, хөтөлбөрт зарцуулах боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат зээлийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг зөв тооцох, Баянхонгор аймагт ногоон хөгжил, бэлчээрийн доройтолтой тэмцэх төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх, цаашид сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээнд зарцуулдаг төслийн санхүүжилтийг багасгах, төсөл хэрэгжих аймаг, сумдыг ямар шалгуураар сонгосон талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Төв аймгийн Зуунмод, Баянчандмань, Лүн, Угтаал зэрэг сумдад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар, санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн албан ёсны монгол орчуулгыг сайжруулах шаардлагатай байгааг холбогдох байгууллагууд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны хомсдол зэрэг тулгамдсан асуудал ихтэй Өмнөговь аймгийг уг төсөл хөтөлбөрт ямар шалтгааны улмаас хамруулаагүй болох, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан “Орхон-Онги” төслийн хэрэгжилт ямар байгаа талаар ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төслийн санхүүжилтээр зохион байгуулдаг сургалт, семинар, судалгааны ажлыг багасгах, өөрсдийн нөөц бололцоогоор дотооддоо хийж болох ажилд эрдэмтэд, судлаачдаа ашиглах, төсөл хөтөлбөр, гэрээ, зээлийн хэлэлцээрийн орчуулгыг зөв хийх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шаардлагатай аймаг, сумдад төсөл, хөтөлбөр хэрэгжихгүй байгааг анхаарах, цөлжилт, хөрсний

доройтол бий болсон говь, тал хээрийн бүсийн аймаг, сумдад хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хөтөлбөр, зээлийн зориулалтыг цөлжиж байгаа, бэлчээр худаг ус ширгэсэн, нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдад хэрэгжүүлэх, бодитой судалгаа хийх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан уг төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Ногоон хувьсгал"-ын хүрээнд хийгдэж байгаа ажлуудын нэг бөгөөд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болбол иргэдээ эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах том ажлын эхлэл болохыг онцлоод, энэхүү хөтөлбөр нь бүсчилсэн ногоон хөгжлийг хангах, бэлчээрийн доройтлыг бууруулах, агро бизнес эрхлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, хөдөө аж ахуйн паркуудыг байгуулах, урт хугацаатай, бага хүүтэй хөгжлийн зээлээс гадна 78 сая ам.долларын буцалтгүй тусламжийг авах боломжтой болно гэв.


Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН